

БАЙГУУЛЛАГЫН "БИЧИГ ХЭРГИЙН МАТЕРИАЛ ХУДАЛДАН АВАХ" ЭМДЕГ/2025010201
ДУГААРТАЙ ТЕНДЕРИЙН НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ
ХОРООНЫ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 3-р сарын 06-ны өдөр

Дугаар: 01

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн А/27 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороо 2025 оны 3 дугаар сарын 06-ны өдөр 15:00-17:20 цагт Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын хурлын танхимд хуралдав. Хурлыг үнэлгээний хорооны дарга Д.Ганбаяр удирдаж, Нарийн бичгийн дарга С.Сувд-Эрдэнэ, гишүүд Д.Булгантамир, Б.Наранбаатар Н.Гонгоржав нар оролцов. Хурлын ирц 100 хувь.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Байгууллагын 2025 оны албан хэрэгцээнд ашиглах "Бичиг хэргийн материал худалдан авах" нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичиг боловсруулах тухай.

Д.Ганбаяр:

"Бичиг хэргийн материал худалдан авах" тендерийн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичгийг боловсруулах ажлыг хэлэлцэх үнэлгээний хорооны хурлыг нээж байна.

Н.Гонгоржав:

Төсөвт өртгийн харахад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасны дагуу Харьцуулалтын тендер шалгаруулалтын аргаар тендер шалгаруулалтыг зохион байгуулъя.

С.Сувд-Эрдэнэ:

Тендерийн баримт бичигт тусгах техникийн тодорхойлолт, тоо хэмжээг манай байгууллагын үйл ажиллагаа хариуцсан санхүүгийн холбогдох мэргэжилтнүүд гаргаж өгсөн байгаа тэдний саналд тусган баримт бичгээ боловсруулж оролцогчийн санхүүгийн болон бусад холбогдох шаардлага баримт бичигт тусгаж боловсруулах зүйтэй болов уу гэж үзэж байна. Ямар шалгуур үзүүлэлт оруулах талаар хэлэлцэх саналтай байна.

Д.Ганбаяр: Гишүүн тус бүр саналаа хэлье. Миний хувьд 2023, 2024 онуудын аль нэг жилийн борлуулалтын орлогын хэмжээ нь тухайн батлагдсан төсөвт өртгийн 50 хувиас багагүй байна гэж оруулах саналтай байна.

Н.Гонгоржав: Сүүлийн 3-н жилийн ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээллийг ирүүлэхийг шаардах уу. Нэг бол сүүлийн 2 жил ч байсан ч болно л доо би бол ийм саналтай байна.

С.Сувд-Эрдэнэ: Тийм шүү дэмжиж байна. Тендерийн бичиг баримтын өгөгдлийн хүснэгтдээ тодорхой энэ асуудлыг тусгаж өгье.

Д.Ганбаяр: 2022, 2023 онуудын санхүүгийн тайланг цахим системээр дамжуулан Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн www.e-balance.mof.gov.mn мэдээллийн системээс тендерт оролцогчдын санхүүгийн тайлангаас сүүлийн 2 жилийн борлуулалтын орлого болон бусад шаардлагатай мэдээллийг шалган гэж оруулах саналтай байна.

Д.Булгантамир: Санал нэг байна.

Н.Гонгоржав: Санал нэг байна

Б.Наранбаатар: Би ч гэсэн санал нэг байна.

Д.Ганбаяр: Боловсруулсан баримт бичгийг батлуулан, tender.gov.mn цахим системд оруулахад бэлдэх ажлыг үнэлгээний хорооны нарийн бичиг хариуцъя.

С.Сувд-Эрдэнэ: Ойлголоо.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

“Бичиг хэргийн материал худалдан авах” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичгийг боловсруулан 2025 оны 3 дугаар сарын 06-ны өдөр tender.gov.mn цахим системд тендер шалгаруулалтын баримт бичгийг оруулж, тендер шалгаруулалтыг эхлүүлэхээр шийдвэрлэв.

Үнэлгээний хорооны дарга:

 Д.Ганбаяр

Гишүүд:

 Д.Булгантамир

 Б.Наранбаатар

 Н.Гонгоржав

Нарийн бичгийн дарга:

 С.Сувд-Эрдэнэ

**БАЙГУУЛЛАГЫН” БИЧИГ ХЭРГИЙН МАТЕРИАЛ ХУДАЛДАН АВАХ” ЭМДЕГ/2025010201
ДУГААРТАЙ ТЕНДЕРИЙН НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ
ХОРООНЫ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2025 оны 4-р сарын 03-ны өдөр

Дугаар: 02

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн А/40 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороо 2025 оны 4 дүгээр сарын 03-ны өдөр 15:00-17:20 цагт Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын хурлын танхимд хуралдав. Үнэлгээний хорооны өүрэлдэхүүнд өөрчлөлт орсон тул дахин тушаал гаргасан байна. Хурлыг үнэлгээний хорооны дарга Ч.Оргилтуяа удирдаж, Нарийн бичгийн дарга С.Сувд-Эрдэнэ, гишүүд Д.Булгантамир, Б.Наранбаатар Н.Гонгоржав нар оролцов. Хурлын ирц 100 хувь.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Байгууллагын 2025 оны албан хэрэгцээнд ашиглах “Бичиг хэргийн материал худалдан авах” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичиг боловсруулах тухай.

Ч.Оргилтуяа:

“Бичиг хэргийн материал худалдан авах” тендер 2 дахь удаагаа зарлагдаж байгаа эхнийх дээр оролцогч материал ирүүлээгүй гэж сонссон. Мөн өмнөх үнэлгээний хорооны дарга нь ажлаа өгсөн тул дахиж үнэлгээний хороо байгуулагдаж ажиллаж байгааг энд хэлсэн нь зүйтэй болов уу гэж бодож байна. Ингээд нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичгийг боловсруулах ажлыг хэлэлцэх үнэлгээний хорооны хурлыг нээж байна. Өмнө нь нэг зарлаад оролцогч материал ирүүлээгүйгийн учир шалтгаан нь юу байсан бэ тодруулах гэсэн юм.

С.Сувд-Эрдэнэ:

Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон тухай гишүүдэд би мэдэгдсэн байгаа. Оролцогч материал ирүүлээгүй талаар тайлбар хийе. Манай байгууллагаас өгсөн тоо хэмжээ үнийн дүнгээс хэт их байсан учир оролцогч материал ирүүлээгүй гэж ойлгосон. Бас нягталж үзэхэд тийм байсан.

Одоо ахиж тоо хэмжээгээ аваад засаад дахин зарлах гэж байна.

Н.Гонгоржав:

Техникийн тодорхойлолтоо засаад өөр засах зүйлгүйгээр оруулахад болно гэж бодож байна зөв үү.

С.Сувд-Эрдэнэ:

Тиймээ зөв. Би тоо хэмжээг нь санхүүгээс аваад бэлдсэн байгаа.

Ч.Оргилтжяа:

Гишүүн тус бүр саналаа хэлье.

Н.Гонгоржав:

Анхны хурал дээр санал гаргасан байсан учраас тэр саналаараа явна надаа санал байхгүй байна.

С.Сувд-Эрдэнэ:

Надад бас санал байхгүй байна тоо хэмжээгээ засаад болох байх

Д.Булгантамир:

Санал нэг байна.

Н.Гонгоржав:

Санал нэг байна

Б.Наранбаатар:

Би ч гэсэн санал нэг байна.

Ч.Оргилтуяа:

Боловсруулсан баримт бичгийг батлуулан, tender.gov.mn цахим системд оруулахад бэлдэх ажлыг үнэлгээний хорооны нарийн бичиг хариуцъя.

С.Сувд-Эрдэнэ: Ойлголоо.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

“Бичиг хэргийн материал худалдан авах” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичгийг боловсруулан tender.gov.mn цахим системд тендер шалгаруулалтын баримт бичгийг оруулж, тендер шалгаруулалтыг эхлүүлэхээр шийдвэрлэв.

Үнэлгээний хорооны дарга:

Гишүүд:

Нарийн бичгийн дарга:

Ч.Оргилтуяа

Д.Булгантамир

Б.Наранбаатар

Н.Гонгоржав

С.Сувд-Эрдэнэ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН

ДАРГА С.ЭНХБОЛД ТАНАА

2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр

№03

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/40 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороо 2025 оны 4 дүгээр сарын 07-ны өдөр зарласан "Бичиг хэргийн материал худалдан авах" ЭМДЕГ/2025010201 дугаартай тендерийг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 34 дүгээр зүйлийг үндэслэн Харьцуулалтын тендер шалгаруулалтыг зохион байгууллаа.

Тендерийг 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 14:00 минутад нээхэд "ПНЖ" ХХК, "ГОЛДЕН ШИЛЛ ГРУПП ХХК, "ГРИЙТПИЙТ" ХХК, "АЗ ХУР" ХХК, "ЗӨВ-ӨНГӨ" ХХК зэрэг 5 байгууллагаас тендерийн материал ирүүлсэн байна.

Тендерийн материал ирүүлсэн компаниануудаас "ЗӨВ-ӨНГӨ" ХХК нь тендерийн баримт бичгийн шаардлагыг бүхэлд нь хангасан болно.

Иймээс Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалтын дагуу "хамгийн сайн" үнэлэгдсэн тендерээр шалгарсан "ЗӨВ-ӨНГӨ" ХХК-тай гэрээ байгуулахыг захиалагчид зөвлөмж хүргүүлж байна.

ЗӨВЛӨМЖ ХҮРГҮҮЛСЭН

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА:

ГИШҮҮН:

Ч.ОРГИЛТУЯА

Д.БУЛГАНТАМИР

Б.НАРАНБААТАР

Н.ГОНГОРЖАВ

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

С. СУВД-ЭРДЭНЭ

**БАЙГУУЛЛАГЫН" БИЧИГ ХЭРГИЙН МАТЕРИАЛ ХУДАЛДАН АВАХ" ЭМДЕГ/2025010201
ДУГААРТАЙ ТЕНДЕРИЙН НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ
ХОРООНЫ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2025 оны 05-р сарын 07-ны өдөр

Дугаар: 04

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн А/40 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороо 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр 11:00-12:20 цагт Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын хурлын танхимд хуралдав. Хурлыг үнэлгээний хорооны дарга Ч.Оргилтуяа удирдаж, Нарийн бичгийн дарга С.Сувд-Эрдэнэ, гишүүд Д.Булгантамир, Б.Наранбаатар Н.Гонгоржав нар оролцов. Хурлын ирц 100 хувь.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Гарсан гомдолын дагуу хугацаа сунгах тухай:

С.Сувд-Эрдэнэ:

Байгууллагын 2025 оны албан хэрэгцээнд ашиглах "Бичиг хэргийн материал худалдан авах" нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерт Аз хур ХХК, Зөв-Өнгө ХХК, Грийтпийк ХХК, ПНЖ ХХК, Голден шил ХХК зэрэг газруудаас ирснийг бид үнэлгээг хийж Зөв-Өнгө ХХК-с ирүүлсэн материалыг хамгийн сайн тендер ирүүлсэн байна гэж сонгон шалгаруулалтыг хийсэн боловч ПНЖ ХХК-с Сангийн яаманд гомдол гаргасан байна.

Ч.Оргилтуяа:

Ерөнхий мэдээллийг нарийн бичиг өгсөн тул гишүүд саналаа хэлэх үү.

Н.Гонгоржав:

Сангийн Яамнаас ямар шийдвэр гаргах нь одоогоор мэдэхгүй учир манай үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл бусад холбогдох материалтай танилцаад ирүүлсэн зөвлөмжийг харж байж дараагийн шийдвэр гарах байх.

Ч.Оргилтуяа:

Гишүүн тус бүр саналаа хэлье.

Б.Наранбаатар:

"Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 34.9.Үнийн санал дуудах ажиллагаа хаагдахад эцсийн үнийг өсөх дарааллаар эрэмбэлж, эхэнд эрэмбэлэгдсэн үнийн санал бүхий оролцогчийн тендерийг хянан үзэж, шаардлага хангасан бол гэрээ байгуулах эрх олгоно. Гэж заасныг бариад үнэлгээгээгээ хийсэн бид буруу ойлгосон болж таарлаа тэ.

Н.Гонгоржав:

Харин тийм л юмшиг байна.

Б.Наранбаатар:

Сангийн яамнаас гомдол хянаж үзээд ямар хариу өгөхийг харж байгаад шийдвэр гаргах нь дээр байхаа.

Д.Булгантамир:

Санал нэг байна.

Н.Гонгоржав:

Санал нэг байна

Д.Булгантамир:

Д.Булгантамир:

Өмнөн бид бүх материалтай танилцаж байсан болохоор нэг их цаг хугацаа орохгүй байх гэж бодож байна.

Н.Гонгоржав:

Тиймээ.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Бүх гишүүд материалуудтай дахин танилцаж ПНЖ ХХК-ийн үнийн санал нь 79,288,528 төгрөгөөс 12,289,721 хөнгөлөлт үзүүлж 66,998,807 төгрөг болж байгаан тогтоогдсон тул санал нэгтгэйгээр ПНЖ ХХК-д гэрээ байгуулах эрх олгох, бусад газарт мэдэглэд хүргүүлэх, захиалагчид зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Үнэлгээний хорооны дарга:

Ч.Оргилтуяа

Гишүүд:

Д.Булгантамир

Б.Наранбаатар

Н.Гонгоржав

Нарийн бичгийн дарга:

С.Сувд-Эрдэнэ

**БАЙГУУЛЛАГЫН" БИЧИГ ХЭРГИЙН МАТЕРИАЛ ХУДАЛДАН АВАХ"
ЭМДЕГ/2025010201 ДУГААРТАЙ ТЕНДЕРИЙН НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН
ШАЛГАРУУЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2025 оны 06-р сарын 03-ны өдөр

Дугаар: 05

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн А/40 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороо 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр 11:00-12:20 цагт Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын хурлын танхимд хуралдав. Хурлыг үнэлгээний хорооны дарга Ч.Оргилтуяа удирдаж, Нарийн бичгийн дарга С.Сувд-Эрдэнэ, гишүүд Д.Булгантамир, Б.Наранбаатар Н.Гонгоржав нар оролцов. Хурлын ирц 100 хувь.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Гарсан гомдолын дагуу дахин үнэлгээ хийх, захиалагчид зөвлөмж хүргүүлэх, оролцогчид мэдэгдэл хүргүүлэх тухай:

Ч.Оргилтуяа:

Байгууллагын 2025 оны албан хэрэгцээнд ашиглах "Бичиг хэргийн материал худалдан авах" нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерт Аз хур ХХК, Зөв-Өнгө ХХК, Грийтпийк ХХК, ПНЖ ХХК, Голден шил ХХК зэрэг газруудаас ирснийг бид үнэлгээг хийж Зөв-Өнгө ХХК-с ирүүлсэн материалыг хамгийн сайн тендер ирүүлсэн байна гэж сонгон шалгаруулалтыг хийсэн боловч ПНЖ ХХК-с Сангийн яаманд гомдол гаргасан. Гаргасан гомдолын дагуу Сангийн Яам гомдлыг хянаж үзээд албан бичиг ирүүлсэн байна. СЯ-ны бичгийг агуулгаар нь танилцуулаад уншсан дээр байх. Үүнд:

..... "ПНЖ" ХХК-ийн гомдолд тус компанийн тендерээс хуулийн 34 дүгээр зүйлийн 34.9 дэх хэсэгт заасан эрэмбийн 5-д эрэмбэлэгдсэн гэж татгалзсан захиалагчийн шийдвэрийг хянан үзэхийг хүссэн байна. Гомдолд дурдсаны дагуу "ПНЖ" ХХК-ийн тендерийг хянан үзлээ. Хуулийн 34 дүгээр зүйлийн 34.8 дахь хэсэгт "Үнийн санал дуудах ажиллагааны туршид оролцогчийн мэдээлэл нууц байх бөгөөд оролцогч цахим системээс олгосон ялгах дугаарыг ашиглаж, заасан хугацаанд үнийн саналыг бууруулан хэдэн ч удаа ирүүлж болно" гэж, мөн зүйлийн 34.9 дэх хэсэгт "Үнийн санал дуудах ажиллагаа хаагдахад эцсийн үнийг өсөх дарааллаар эрэмбэлж, эхэнд эрэмбэлэгдсэн үнийн санал бүхий оролцогчийн тендерийг хянан үзэж, шаардлага хангасан бол гэрээ байгуулах эрх олгоно" гэж, 34.10 дахь хэсэгт "Энэ хуулийн 34.9-д зааснаар хянан үзэхэд тендер шаардлагад нийцээгүй бол удаах эрэмбэлэгдсэн тендерийг хянан үзнэ" гэж тус тус заасан. Үнэлгээний хорооны 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаар хурлын тэмдэглэлд "ПНЖ" ХХК-ийг 79,288,528.0 төгрөгийн үнийг санал болгосон гэж дурдсан байна. Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр ирүүлсэн "ПНЖ" ХХК-ийн тендер илгээх 1 дүгээр маягтад "... тендер

шалгаруулалтад 79,288,528.0 төгрөгөөр тендер шалгаруулалтын баримт бичигт заасан хуваарийн дагуу бараа нийлүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид "тендер" гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд: 4. Тендерт үнийн хөнгөлөлт санал болгоно. 12,289,721.0 Төгрөг" гэж заасан буюу тус компани нь тендерт 66,998,807.0 төгрөгийн үнийг санал болгосон байх тул тус компаниас хуулийн 34 дүгээр зүйлийн 34.9 дэх 9766007776 хэсэгт заасан эрэмбийн 5-д эрэмбэлэгдсэн гэж татгалзсан захиалагчийн шийдвэр үндэслэлгүй байна. Иймд хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.1 дэх заалтыг үндэслэн захиалагчийн 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 01/1090 тоот шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэж байна. Тендер шалгаруулалтын тендер хянан үзэх, үнэлэх ажиллагааг хуульд нийцүүлэн дахин хийхийг хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.2 дахь заалтыг үндэслэн мэдэгдье. Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг түдгэлзүүлсэн шийдвэрийн хугацаа үүгээр дуусгавар болно. Гэжээ тэгэхээр хэдүүлээ ирүүлсэн материалуудаа дахин үнэлж шийдвэр гаргасан нь дээр байх.

С.Сувд-Эрдэнэ:

Тиймээ санал нэг байна.

Н.Гонгоржав:

Санал нэг байна.

Ч.Оргилтуяа:

Гишүүн тус бүр саналаа хэлье.

Б.Наранбаатар:

"Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 34.9.Үнийн санал дуудах ажиллагаа хаагдахад эцсийн үнийг өсөх дарааллаар эрэмбэлж, эхэнд эрэмбэлэгдсэн үнийн санал бүхий оролцогчийн тендерийг хянан үзэж, шаардлага хангасан бол гэрээ байгуулах эрх олгоно. Гэж заасныг бариад үнэлгээгээгээ дахин хийсэн дээрээ. Би бол энэ заалтыг барих талаар хурал болгон дээр л ярьж байна даа.

Н.Гонгоржав:

Харин тиймээ.

Д.Булгантамир:

Бид өмнөх хурлаараа ирүүлсэн бүх материалыг хянаж үзээд ПНЖ ХХК, Грийтпийт ХХК-д шаардлага хангаж байгаа хэдий ч үнийн санал нь өндөр байна. ПНЖ ХХК-н 12,289,721-н хөнгөлөлт үзүүлээд 79,288,528 юм байна гэж дүгнэсэн нь алдаатай болсон байна. Иймээс бид үнэлгээг дахин хийх, хугацаа сунгуулах зөвлөмж хүргүүлэх шаардлага үүсээд байна гэж ойлгож болох уу.

Н.Гонгоржав:

Тиймээ.

С.Сувд-Эрдэнэ:

Д.Булгантамир гишүүн зөв ойлгосон байна. Дахин бүх материалаа үнэлэхэд санал нэг байна

Ч.Оргилтуяа:

За тэгүүл Сангийн яамнаас ирсэн бичгийг үндэслэн дахин үнэлгээгээ хийе.

Санал нэг байна

Ч.Оргилтуяа:

За тэгүүл СЯ-с ирэх гомдол хянсан хариу бичгийг үндэслэн дараагийн арга хэмжээг авах уу. Бүх гишүүд санал нэгтэй дэмжсэн.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Сангийн Яамнаас ирэх гомдол хянсан бичгийг үндэслэн шийдвэр гаргахаар шийдвэрлэв.

Үнэлгээний хорооны дарга:

Ч.Оргилтуяа

Гишүүд:

Д.Булгантамир

Б.Наранбаатар

Н.Гонгоржав

Нарийн бичгийн дарга:

С.Сувд-Эрдэнэ

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Манай газраас зарласан “Бичиг хэргийн материал худалдан авах” ЭМДЕГ/2025010201 дугаартай тендер шалгаруулалтад ирүүлсэн танай тендер Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалтын дагуу “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерээр шалгарсан тул гэрээ байгуулах эрх олгож буйг үүгээр мэдэгдэж байна.

Тендерийн харьцуулах үнэ: 89,806,700 төгрөг

Гэрээний үнэ: 66,826,631 төгрөг

Энэхүү мэдэгдлийг хүлээн авснаас хойш 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор худалдан авах гэрээг баталгаажуулж ирүүлнэ үү.

ДАРГА  С.ЭНХБОЛД

“ГОЛДЕН ШИЛЛ ГРУПП” ХХК-Д

Мэдэгдэл хүргүүлэх тухай


”Бичиг хэргийн материал худалдан авах”, ЭМДЕГ/2025010201-ын тендер шалгаруулалтад ирүүлсэн танай тендер Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь хэсэгт заасны дагуу дараах шаардлагыг хангаагүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

№	Захиалагчийн тавьсан шаардлага	Оролцогчийн санал	Шалгараагүй тухай тайлбар
1	ТШЗ 16.2 Тендер шалгаруулалт зарласнаас хойш хугацаанд цахим системээс авсан нийгмийн даатгалын шимтгэл болон татварын өр төлбөргүй тодорхойлолтыг цахим системийн холбогдох талбараар зааварчилгааны дагуу тус тус ирүүлнэ. Энэхүү тодорхойлолтыг ирүүлээгүй тохиолдолд тендер нээсэн өдрийн байдлаар татвар нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өр төлбөрийн талаарх мэдээллийг шалгана.	Монголын татварын албаны 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 25.1003.6911df92-2606-45fb-9183-bc68405b8d0c дугаартай тодорхойлолт ирүүлсэн байна.	14,446,004.34 төгрөгийн татварын өртэй байна.

Дээрх тендер шалгаруулалтад “ПНЖ” ХХК-нд гэрээ байгуулах эрх олгосон мэдэгдэл хүргүүлсэн болно.

Та энэхүү мэдэгдлийг хүлээн зөвшөөрч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасны дагуу гомдол гаргахгүй, тендер шалгаруулалтад цаашид оролцохгүй тохиолдолд дээр дурдсан тендер шалгаруулалт, түүний багцад гаргасан баталгааг цуцлуулах хүсэлтийг гаргах эрхтэй.

ДАРГА



С.ЭНХБОЛД

“ЗӨВ-ӨНГӨ” ХХК-д

Мэдэгдэл хүргүүлэх тухай

“Бичиг хэргийн материал худалдан авах” ЭМДЕГ/2025010201-ын тендер шалгаруулалтад танай ирүүлсэн тендер Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.9 дэх хэсэгт заасан эрэмбийн 2-д эрэмбэлэгдсэн болно.

Дээрх тендер шалгаруулалтад “ПНЖ” ХХК-нд гэрээ байгуулах эрх олгосон мэдэгдэл хүргүүлсэн болно.

ДАРГА



С.ЭНХБОЛД

“ГРИЙТПИЙК” ХХК-д

Мэдэгдэл хүргүүлэх тухай

“Бичиг хэргийн материал худалдан авах” ЭМДЕГ/2025010201-ын тендер шалгаруулалтад танай ирүүлсэн тендер Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.9 дэх хэсэгт заасан эрэмбийн 4-д эрэмбэлэгдсэн болно.

Дээрх тендер шалгаруулалтад “ПНЖ” ХХК-нд гэрээ байгуулах эрх олгосон мэдэгдэл хүргүүлсэн болно.

ДАРГА



С.ЭНХБОЛД

“АЗ ХҮР” ХХК-Д

Манай газраас зарласан “Бичиг хэргийн материал худалдан авах”, ЭМДЕГ/2025010201 дугаартай тендер шалгаруулалтад ирүүлсэн танай тендерээс Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсэгт Захиалагч энэ хуулийн 27.3-т заасан арифметик алдааг залруулснаас бусад тохиолдолд тендерийн үнэ, үнийн хөнгөлөлтийн талаар тодруулга авах хүсэлт гаргах боломжгүй учир танай ирүүлсэн тендерээс татгалзаж байгааг үүгээр мэдэгдэж байна.

ДАРГА



С.ЭНХБОЛД

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН

ДАРГА С.ЭНХБОЛД ТАНАА

2025 оны 06 дүгээр
сарын 03-ны өдөр

№04

Улаанбаатар
хот.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/40 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороо 2025 оны 4 дүгээр сарын 07-ны өдөр зарласан "Бичиг хэргийн материал худалдан авах" ЭМДЕГ/2025010201 дугаартай тендерийг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 34 дүгээр зүйлийг үндэслэн Харьцуулалтын тендер шалгаруулалтыг зохион байгуулсан.

Тендерийг 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 14:00 минутад нээхэд "ПНЖ" ХХК, "ГОЛДЕН ШИЛЛ ГРУПП ХХК, "ГРИЙТГИЙТ" ХХК, "АЗ ХУР" ХХК, "ЗӨВ-ӨНГӨ" ХХК зэрэг 5 байгууллагаас тендерийн материал ирүүлсэн байна.

Тендерт ирүүлсэн компаниануудаас шаардлагыг бүхэлд нь хангасан байна гэж "ЗӨВ-ӨНГӨ" ХХК-г сонгон шалгаруул зөвлөмж мэдэгдэлийг хүргүүлсэн боловч ПНЖ ХХК-ийс Сангийн яаманд гомдол гаргасан байна.

Тус тендерийн хүчинтэй байх хугацаа 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр дууссан тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсэгт заасны дагуу тендерийн хүчинтэй байх хугацааг сунгаж өгнө үү.

Сангийн яамнаас ирүүлсэн 2025 оны 02/4415 дугаартай "Гомдол хянах тухай" албан бичгийн дагуу тендерийг дахин хянан үзэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалтын дагуу "хамгийн сайн" үнэлэгдсэн тендерээр шалгарсан "ПНЖ" ХХК-тай гэрээ байгуулахыг захиалагчид зөвлөмж хүргүүлж байна.

ЗӨВЛӨМЖ ХҮРГҮҮЛСЭН

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА:

ГИШҮҮН:

Ч.ОРГИЛТУЯА

Д.БУЛГАНТАМИР

Б.НАРАНБААТАР

Н.ГОНГОРЖАВ

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

С. СУВД-ЭРДЭНЭ



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2025.05.19 № 02/4415
танай _____-ны № _____-т

Гомдол хянасан тухай

Танай байгууллагаас зарласан ЭМДЕГ/20250202001 дугаартай "Бичиг хэргийн материал худалдан авах" тендер шалгаруулалтад оролцсон "ПНЖ" ХХК-аас гаргасан гомдлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /цаашид "хууль" гэх/-ийн 59 дүгээр зүйлийн 59.8 дахь хэсэг болон Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам"-д заасны дагуу захиалагчаас ирүүлсэн холбогдох баримт материалд үндэслэн хянан үзлээ.

"ПНЖ" ХХК-ийн гомдолд тус компанийн тендерээс хуулийн 34 дүгээр зүйлийн 34.9 дэх хэсэгт заасан эрэмбийн 5-д эрэмбэлэгдсэн гэж татгалзсан захиалагчийн шийдвэрийг хянан үзэхийг хүссэн байна.

Гомдолд дурдсаны дагуу "ПНЖ" ХХК-ийн тендерийг хянан үзлээ.

Хуулийн 34 дүгээр зүйлийн 34.8 дахь хэсэгт "Үнийн санал дуудах ажиллагааны туршид оролцогчийн мэдээлэл нууц байх бөгөөд оролцогч цахим системээс олгосон ялгах дугаарыг ашиглаж, заасан хугацаанд үнийн саналыг бууруулан хэдэн ч удаа ирүүлж болно" гэж, мөн зүйлийн 34.9 дэх хэсэгт "Үнийн санал дуудах ажиллагаа хаагдахад эцсийн үнийг өсөх дарааллаар эрэмбэлж, эхэнд эрэмбэлэгдсэн үнийн санал бүхий оролцогчийн тендерийг хянан үзэж, шаардлага хангасан бол гэрээ байгуулах эрх олгоно" гэж, 34.10 дахь хэсэгт "Энэ хуулийн 34.9-д зааснаар хянан үзэхэд тендер шаардлагад нийцээгүй бол удаах эрэмбэлэгдсэн тендерийг хянан үзнэ" гэж тус тус заасан.

Үнэлгээний хорооны 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаар хурлын тэмдэглэлд "ПНЖ" ХХК-ийг 79,288,528.0 төгрөгийн үнийг санал болгосон гэж дурдсан байна.

Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр ирүүлсэн "ПНЖ" ХХК-ийн тендер илгээх 1 дүгээр маягтад "... тендер шалгаруулалтад 79,288,528.0 төгрөгөөр тендер шалгаруулалтын баримт бичигт заасан хуваарийн дагуу бараа нийлүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид "тендер" гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд: 4.Тендерт үнийн хөнгөлөлт санал болгоно. 12,289,721.0 Төгрөг" гэж заасан буюу тус компани нь тендерт 66,998,807.0 төгрөгийн үнийг санал болгосон байх тул тус компаниас хуулийн 34 дүгээр зүйлийн 34.9 дэх

хэсэгт заасан эрэмбийн 5-д эрэмбэлэгдсэн гэж татгалзсан захиалагчийн шийдвэр үндэслэлгүй байна.


Иймд хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.1 дэх заалтыг үндэслэн захиалагчийн 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 01/1090 тоот шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэж байна.

Тендер шалгаруулалтын тендер хянан үзэх, үнэлэх ажиллагааг хуульд нийцүүлэн дахин хийхийг хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.2 дахь заалтыг үндэслэн мэдэгдье.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг түдгэлзүүлсэн шийдвэрийн хугацаа үүгээр дуусгавар болно.

Хувийг: "ПНЖ" ХХК-д.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Ж.ГАНБАТ

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо: **2025 оны 2 дугаар сарын 27**
Тендер шалгаруулалтын төрөл: Бараа
Тендер шалгаруулалтын нэр: **Бичиг хэргийн материал худалдан авах**
Тендер шалгаруулалтын дугаар: **ЭМДЕГ/2025010201**
Нийт төсөвт өртөг: **89,806,700**
Тендер шалгаруулалтын арга: Харьцуулалт

1. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.
2. Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: **Багцгүй**
3. Үнийн санал дуудах ажиллагаанд шаардлагатай оролцогчийн тоо: **2 ба түүнээс дээш**
4. Үнийн санал дуудах ажиллагаанд бүртгүүлэх журам: **Бага үнийн санал**
5. Үнийн санал дуудах ажиллагааг **2025 оны 3 дугаар сарын 10-ны 11: 00 цагаас эхлүүлж 13:00 цаг** хугацаанд зохион байгуулна.
6. Тендерийг **2025 оны 3 дугаар сарын 10-ны 09:00 цагаас** өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба тендерийг **2025 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн, 11 -т** нээнэ.
7. Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: **“Зөвшөөрөхгүй”**
8. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: **“Эрхгүй”**
9. Тендер нь түүнийг нээснээс хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заана.
10. Оролцогч цахим системийн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээх эрхтэй байна.

Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн
20 дугаар хороо өөрийн байр
Утас: 70101686
Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар.

ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ
[Тендер шалгаруулалтын нэрийг бичих] гэрээ.
Дугаар № **[Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]**

..... хот/аймаг
Нэг талаас **[захиалагчийн нэрийг бичих]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэрийг бичих]** (цаашид “нийлүүлэгч” гэх) нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Нийлүүлэгчийн хооронд бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Бараа” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.


1. Энэ гэрээний дагуу нийлүүлэх Барааны үнэ нь **[гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих]** төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Нийлүүлэгч **[Нийлүүлэгчийн нэрийг бичих]**-ийн харилцах **[Банкны нэрийг бичих]** банкны **[дансны дугаар бичих]** дугаар дансанд шилжүүлнэ.
3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
 - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 - 3.2. Нийлүүлэгч тендер илгээсэн маягт;
 - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
 - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
 - 3.5. Техникийн тодорхойлолт;
 - 3.6. Бараа нийлүүлэлтийн хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
 - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:
 - 4.2. Нийлүүлэгчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____



**АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛГҮЙ ГЭДГЭЭ ИЛЭРХИЙЛЭХ,
ЗӨРЧИЛ ҮҮССЭН ТУХАЙ МЭДЭГДЭЛ**

Нэг. Нийтийн албан тушаалтан

Ургийн овог:	Эцэг (эх)-ийн нэр: <i>Сайн нойд</i>	Нэр: <i>Сүхэрийн</i>
Албан тушаал: <i>Чистотиний хорооно корпусын бичиг</i>	Ажиллаж байгаа байгууллага: <i>МОНЕТ</i>	
Албан тушаалд томилогдсон он, сар, өдөр: <i>2025.2.20-ны өдрийн А/27 тушаал</i>	Байгууллагын хаяг: <i>МОНЕТ</i>	
Албан үүргийн төрөл: <i>У/Х/сэрв</i>	Тайлбар: "Бичиг хэргийн материал худалдан авах", "Цэвэрлэгээний материал худалдан авах" бараа нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажил.	

Сонирхлын зөрчилтэй эсэх

☐

Тийм

☒

Үгүй

Хоёр. Сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн байдал

Нийтийн албан тушаалтан *С. Сүхэрийн* би
дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэхэд Нийтийн албанд нийтийн
болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх
тухай хуульд заасан сонирхлын зөрчилгүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

Гурав. Сонирхлын зөрчил үүссэн тухай

Нийтийн албан тушаалтан би дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэх
хүрээнд:

☐

гаргах, гаргахад оролцох шийдвэр нь хамаарал бүхий этгээдтэй холбоотой гэх
/хувь хүн, хуулийн этгээдийн нэр, үйл ажиллагааны
чиглэл/:

☐

гэрээ хэлцэл, хэлэлцээрийн оролцогч, эсхүл зээл, хандив, тусламж,
үйлчилгээг хувь хүн, хуулийн этгээдээс авч байсан /байгаа/-тай холбогдуулж

үүрэг хүлээсэн гэх:

**АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛГҮЙ ГЭДГЭЭ ИЛЭРХИЙЛЭХ,
ЗӨРЧИЛ ҮҮССЭН ТУХАЙ МЭДЭГДЭЛ**

Нэг. Нийтийн албан тушаалтан

Ургийн овог:	Эцэг (эх)-ийн нэр: <i>Баянзүрх</i>	Нэр: <i>Норангасар</i>
Албан тушаал: <i>ТББн төлөөлөл</i>	Ажиллаж байгаа байгууллага: -	
Албан тушаалд томилогдсон он, сар, өдөр: <i>2025.2.20-ны өдрийн А/27 тушаал</i>	Байгууллагын хаяг:	
Албан үүргийн төрөл:	Тайлбар: "Бичиг хэргийн материал худалдан авах", "Цэвэрлэгээний материал худалдан авах" бараа нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажил.	

Сонирхлын зөрчилтэй эсэх

☐

Тийм

☐

Үгүй

Хоёр. Сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн байдал

Нийтийн албан тушаалтан *Б. Норангасар* би
дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэхэд Нийтийн албанд нийтийн
болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх
тухай хуульд заасан сонирхлын зөрчилгүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

Гурав. Сонирхлын зөрчил үүссэн тухай

Нийтийн албан тушаалтан би дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэх
хүрээнд:

☐

гаргах, гаргахад оролцох шийдвэр нь хамаарал бүхий этгээдтэй холбоотой гэх
/хувь хүн, хуулийн этгээдийн нэр, үйл ажиллагааны
чиглэл/:

☐

гэрээ хэлцэл, хэлэлцээрийн оролцогч, эсхүл зээл, хандив, тусламж,
үйлчилгээг хувь хүн, хуулийн этгээдээс авч байсан /байгаа/-тай холбогдуулж

үүрэг хүлээсэн гэх:

**АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛГҮЙ ГЭДГЭЭ ИЛЭРХИЙЛЭХ,
ЗӨРЧИЛ ҮҮССЭН ТУХАЙ МЭДЭГДЭЛ**

Нэг. Нийтийн албан тушаалтан

Ургийн овог:	Эцэг (эх)-ийн нэр: <i>Д</i>	Нэр: <i>Бунгантсеев</i>
Албан тушаал: <i>Мн мэрхмэлт</i>	Ажиллаж байгаа байгууллага: <i>МДБ</i>	
Албан тушаалд томилогдсон он, сар, өдөр: <i>2025.2.20-ны өдрийн А/27 тушаал</i>	Байгууллагын хаяг: <i>МДБ</i>	
Албан үүргийн төрөл: <i>мэрг</i>	Тайлбар: "Бичиг хэргийн материал худалдан авах", "Цэвэрлэгээний материал худалдан авах" бараа нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажил.	

Сонирхлын зөрчилтэй эсэх

☐

Тийм

☒

Үгүй

Хоёр. Сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн байдал

Нийтийн албан тушаалтан *Д. Бунгантсеев* би
дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэхэд Нийтийн албанд нийтийн
болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх
тухай хуульд заасан сонирхлын зөрчилгүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

Гурав. Сонирхлын зөрчил үүссэн тухай

Нийтийн албан тушаалтан би дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэх
хүрээнд:

☐

гаргах, гаргахад оролцох шийдвэр нь хамаарал бүхий этгээдтэй холбоотой гэх
/хувь хүн, хуулийн этгээдийн нэр, үйл ажиллагааны
чиглэл/:

☐

гэрээ хэлцэл, хэлэлцээрийн оролцогч, эсхүл зээл, хандив, тусламж,
үйлчилгээг хувь хүн, хуулийн этгээдээс авч байсан /байгаа/-тай холбогдуулж

үүрэг хүлээсэн гэх:

**АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛГҮЙ ГЭДГЭЭ ИЛЭРХИЙЛЭХ,
ЗӨРЧИЛ ҮҮССЭН ТУХАЙ МЭДЭГДЭЛ**

Нэг. Нийтийн албан тушаалтан

Ургийн овог: <i>И. Контел</i>	Эцэг (эх)-ийн нэр: <i>Ариунтүвшин</i>	Нэр: <i>Томторшув</i>
Албан тушаал: <i>нмчүчн</i>	Ажиллаж байгаа байгууллага: <i>Бүрэн итгэмж дайлагч НЧДББ</i>	
Албан тушаалд томилогдсон он, сар, өдөр: <i>2025.2.20-ны өдрийн А/27 тушаал</i>		Байгууллагын хаяг:
Албан үүргийн төрөл: <i>догдлоготомсгол нмчүчн</i>	Тайлбар: "Бичиг хэргийн материал худалдан авах", "Цэвэрлэгээний материал худалдан авах" бараа нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажил.	

Сонирхлын зөрчилтэй эсэх

☐

Тийм

☐

Үгүй

Хоёр. Сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн байдал

Нийтийн албан тушаалтан *Н. Томторшув* би дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэхэд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан сонирхлын зөрчилгүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

Гурав. Сонирхлын зөрчил үүссэн тухай

Нийтийн албан тушаалтан би дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэх хүрээнд:

☐

гаргах, гаргахад оролцох шийдвэр нь хамаарал бүхий этгээдтэй холбоотой гэх /хувь хүн, хуулийн этгээдийн нэр, үйл ажиллагааны чиглэл/: *учуа*

☐

гэрээ хэлцэл, хэлэлцээрийн оролцогч, эсхүл зээл, хандив, тусламж, үйлчилгээг хувь хүн, хуулийн этгээдээс авч байсан /байгаа/-тай холбогдуулж үүрэг хүлээсэн гэх: *учуа*